

Хамрах хүрээ: "Бүрэнфинанс ББСБ" ХХК-ийн үйл ажиллагаа	Хариуцах эзэн: Эрсдэлийн удирдлагын газар
Хувийг хадгалах: Бичиг хэрэг хариуцсан ажилтан	Танилцах: "Бүрэнфинанс ББСБ" ХХК-ийн нийт ажилтнууд
Хэрэгжиж эхлэх хугацаа: 2025-04-29	Хуудасны тоо: 10
Баримт бичгийн дугаар: БФ - 005	Хувилбар: V-2.0

Өөрчлөлтийн түүх

д/д	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1	V-1.0	2024-06-27	ТУЗ-ийн ТЗ24/024 тоот тогтоол, ББСБ-ын дотоод хэрэгцээнд зориулан боловсруулсан.
2	V-2.0	2025-04-28	ISO 27001:2022 стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлын хүрээнд боловсруулж, 2025.04.28-ны ТУЗ-ийн ТЗ25/21 тоот тогтоолоор шинэчлэн батлав. Хавсралт №2
3			
4			

№	ТОВЧ АГУУЛГА	Хуудас
1.	НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
2.	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ	3
3.	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХАМРАХ ХҮРЭЭ	4
4.	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО	4
5.	НЭГЖҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ	5
6.	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ХЭРЭГЖҮҮЛЭХ	6
7.	ХАРИУЦЛАГА	9

№ НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ

1. ББСБ - “Бүрэнфинанс ББСБ”;
2. МБ - “Монгол банк”;
3. СЗХ - “Санхүүгийн зохицуулах хороо”;
4. ТУЗ - “Төлөөлөн удирдах зөвлөл”;
5. ГЗ - “Гүйцэтгэх захирал”;
6. ЭУГ - “Эрсдэлийн удирдлагын газар”;
7. МАБ - “Мэдээллийн аюулгүй байдл”;

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 “Бүрэн Финанс ББСБ”-ын “Эрсдэлийн удирдлагын бодлого” *hуасшилд* “бодлого” гэх/-ын зорилго нь ББСБ-ын эрсдэлийн удирдлагын баримтлах зарчим, эрсдэлийн ангиллыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үе шатыг тогтоох, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлийг удирдахтай холбогдох ажилтан, албан тушаалтан бүрийн эрх, үүргийг тодорхойлох, хянахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх нь ББСБ-ын нийт ажилтан, холбогдох албан тушаалтны хамтын хариуцлага байна. Холбогдох этгээд нь Эрсдэлийн удирдлагын газрыг шаардлагатай мэдээллээр тухай бүр хангах үүрэгтэй.
- 1.3 “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэн батална.
- 1.4 “Эрсдэлийн удирдлагын бодлого” нь Монгол улсын хууль тогтоомж, Монгол банк, “Санхүүгийн зохицуулах хороо”-оос баталсан заавар, журмын нөхцөл шаардлагуудтай нийцтэй байна.

ХОЁР. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ

- 2.1 ББСБ-ын эрсдэлийн удирдлага нь хүлээн зөвшөөрөгдсөн эрсдэлийн түвшинд өгөөжийг хамгийн өндөр байлгах үндсэн зорилтыг хэрэгжүүлнэ.
- 2.2 Энэхүү бодлогыг дараах зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 2.2.1 Хараат бус байх – ЭУГ-ын эрх бүхий ажилтан, албан тушаалтны үйл ажиллагаа, түүний дүгнэлт, тайлан боловсруулах үйл явц хараат бус, бие даасан байх;
 - 2.2.2 Хэмжигдэхүйц байх – эрсдэлийг тоон болон чанарын шинжилгээний аргаар хэмжих ба тоон шинжилгээг суурь арга болгодог байх;
 - 2.2.3 Хамтын шийдвэр гаргадаг байх – шийдвэр гаргах эрх мэдлийг нэг албан тушаалтан эсхүл нэг нэгжид олгохоос зайлсхийх;
 - 2.2.4 Тайлагнадаг байх – эрсдэлийн дүгнэлт, тайланг зөвхөн холбогдох эрх бүхий этгээдэд тайлагнадаг, танилцуулдаг байх;
 - 2.2.5 Бүрэн хамрах – эрсдэлийг илрүүлэхийг эрмэлзэх, тэдгээрийн шалтгаан үр дагаврыг бодитой үнэлэх, албан тушаалтан бүр өөрийн үйл ажиллагааны бүх үе шатанд эрсдэлээс хамгаалах суурь зарчмыг харгалздаг, мөрддөг байх;
 - 2.2.6 Зохистой байх – эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь олон улсын холбогдох стандарт, зарчмын болон зохицуулагч байгууллагаас батлан гаргасан дүрэм, журамд нийцсэн байх;
 - 2.2.7 Шинэчлэгддэг байх – компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, шинэ төсөл хэрэгжүүлэх болсон, салбарын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын бодлого, стратеги өөрчлөгдсөн тохиолдолд тэдгээрт хамаарах эрсдэлийн удирдлагын журам болон тогтолцоонд зохих өөрчлөлтийг тухай бүр хийдэг байх.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХАМРАХ ХҮРЭЭ

- 3.1 Эрсдэлийг шалтгаан, хэмжигдэх байдлаар нь санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэл гэж ангилна. ББСБ-ын үйл ажиллагааны хамрах хүрээ, онцлогоос шалтгаалан дараах эрсдэлүүдийг удирдах, хянахад эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг чиглүүлэнэ. Үүнд:
- 3.1.1 “Зээлийн үйл ажиллагааны эрсдэл” гэдэг зээлийн эргэн төлөлт тасалдах буюу зээлдэгч тогтсон хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлтөө хийж чадаагүйн улмаас ББСБ санхүүгийн алдагдал хүлээх магадлалыг ойлгоно. Төлбөр тооцооны эрсдэл нь санхүүгийн гүйлгээ төлөвлөсний дагуу хийгдэхгүй байх эрсдэл бөгөөд зээлийн эрсдэлийн бүрэлдэхүүн хэсэгт багтана;
 - 3.1.2 “Үйл ажиллагааны эрсдэл” гэдэг нь ББСБ-ын дотоод үйл ажиллагаа, хүмүүс, системүүдийн хяналтын хангалтгүй байдал, гадаад орчны таагүй нөлөөлөл, үйл ажиллагаанаас шалтгаалан алдагдал бий болохыг хэлнэ. Үйл ажиллагааны эрсдэлд дараах төрлийн эрсдэлүүд хамаарахгүй. Үүнд:
 - 3.1.2.1 зээлийн эрсдэл;
 - 3.1.2.2 зах зээлийн эрсдэл;
 - 3.1.2.3 комплаенс, хуулийн эрсдэл;
 - 3.1.2.4 стратеги болон нэр хүндийн эрсдэл;
 - 3.1.2.5 гэрээлэгч талын /Counterparty/ эрсдэл.
 - 3.1.3 “Зах зээлийн эрсдэл” гэдэгт улс төр, зохицуулалтын орчин, эрх зүй, макро эдийн засаг, татвар болон ханшийн өөрчлөлт зэрэг гадаад орчны хүчин зүйлээс хамаарч ББСБ санхүүгийн алдагдал хүлээх, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг ойлгоно;
 - 3.1.4 “Комплаенс, хуулийн эрсдэл” гэж хууль тогтоомж, ББСБ-ын бодлого, дүрэм журам, ёс зүйн хэм хэмжээ зөрчигдсөнөөр зохицуулагч байгууллагын зүгээс хязгаарлалт хийх, торгууль оногдуулах болон ББСБ-ын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх, санхүүгийн алдагдал хүлээх зэрэг эрсдэлүүдийг хэлнэ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүйгээс үүдэн гарах эрсдэлийг хамруулан ойлгоно;
 - 3.1.5 “Хөрвөх чадварын эрсдэл” /Толбор түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл/ гэж харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь биелүүлэх төлбөрийн чадамжгүй болох, эсхүл тухайн үүргийг биелүүлэхэд их хэмжээний нэмэлт зардал гаргах нөхцөл үүсэхийг хэлнэ.
- 3.2 ББСБ-ын эрсдэлийн удирдлагын стратегийн хүрээнд эрсдэлийн ангилал тус бүрээр тусгайлан бодлого, журам боловруулж, хариуцсан нэгж, ажилтнуудын ажиллах үндсэн зарчим, эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

- 4.1 ББСБ нь эрсдэлийн удирдлагын зарчимд суурилан, эрсдэлийн удирдлагын үе шатыг баримталсан гурван давхар хамгаалалтын шугам бүхий эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлнэ.

- 4.2 ББСБ-ын Гүйцэтгэх захирал нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор ажилтнуудыг сургах, мэдээллээр хангах чиглэлд ажлууд зохион байгуулж, ББСБ-ын хэмжээнд эрсдэлийн соёлыг бий болгож, төлөвшүүлнэ.
- 4.3 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хамгаалалтын гурван шугамын зарчимд тулгуурлаж, нэгжүүдийн чиг үүргийг тодорхойлно. Үүнд:
- 4.3.1 Хамгаалалтын нэгдүгээр шугам: Бизнесийн нэгжүүд болон дэмжлэг үзүүлэх нэгжүүд нь хамгаалалтын нэгдүгээр шугамыг бүрдүүлж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ. Нэгж бүр чиг үүргийн хүрээнд учирч болох эрсдэлийг нарийвчлан тодорхойлж үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлэх, үр дүнг эрх бүхий этгээдэд тайлагнах үүрэгтэй;
- 4.3.2 Хамгаалалтын хоёрдугаар шугам: Эрсдэлийн удирдлагын газар /ЭУГ/ нь бодлого боловсруулах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог хянах, эрсдэлийг удирдах аргачлал боловсруулж, хэрэгжүүлэх нэгж байна. Холбогдох хороод болон гүйцэтгэх захирлын зүгээс хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллана;
- 4.3.3 Хамгаалалтын гуравдугаар шугам: Төлөөлөн удирдах зөвлөл, дотоод аудитор нь эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хөндлөнгийн, хараат бус хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж өгөх нэгж байна.
- 4.4 ББСБ-ын нийт ажилтнуудад эрсдэлийн соёлын хэм хэмжээг тогтоож, төлөвшүүлэх нь ТУЗ, гүйцэтгэх удирдлагын баг болон нийт ажилтнуудын хамтын ажиллагаа, бүтээлч хандлагын үр дүн байна.

ТАВ. НЭГЖҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

- 5.1 ББСБ-ын нийт ажилтнууд хариуцсан ажил үүргийн хүрээнд эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, үнэлэх, хянах, тайлагнах зэргээр эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй.
- 5.2 Эрсдэлийн удирдлагын бодлого, дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд холбогдох нэгжүүд дараах үндсэн үүрэгтэй оролцоно. Үүнд:
- 5.2.1 Хамгаалалтын нэгдүгээр шугамд хамаарах нэгж, ажилтнуудын чиг үүрэг:
- 5.2.1.1 хариуцсан чиг үүргийн хүрээнд эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх зохистой арга хэмжээ авах;
- 5.2.1.2 нэгжийн удирдлагын зүгээс хариуцсан нэгжийн үйл ажиллагаанд бүхэлд нь хяналт тавьж, эрсдэл учирсан, учирч болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд шаардлагатай арга хэмжээ нэн даруй авах;
- 5.2.1.3 эрсдэлийн түвшнээс хамаарч асуудлыг шийдвэрлэх санал боловсруулах, ЭУГ, Гүйцэтгэх захиралд цаг тухайд нь мэдэгдэх, эрх бүхий этгээдэд тайлагнах.
- 5.2.2 Хамгаалалтын хоёрдугаар шугамд хамаарах нэгж, ажилтнуудын чиг үүрэг:
- 5.2.2.1 эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийн хэрэгжилтийг хангах;
- 5.2.2.2 үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийн магадлал, үр дагавар, дотоод хяналтын үр ашигт байдлыг үнэлэх, холбогдох аргачлалын дагуу эрсдэлийн дүгнэлт гаргах зэргээр эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

- 7.2.1 ББСБ-ын ёс зүйн дүрэм, ажилтны “Ажлын байрны тодорхойлолт”-д заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж, өндөр хариуцлагатай ажиллах;
 - 7.2.2 Харилцагч болон ББСБ-ын мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах. Холбогдох хууль, журамд заасан үндэслэл, төрийн эрх бүхий байгууллагын хууль ёсны шаардлагаас бусад тохиолдолд харилцагчийн мэдээллийг ил тод болгох, бусдад задруулахыг хориглоно;
 - 7.2.3 ББСБ-ын ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан, мэргэжлийн хандлагатай ажиллах.
- 7.3 ЭУГ-ын захирал нь энэхүү бодлогын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд жил бүр, онцгой тохиолдолд тухай бүр өөрчлөлт оруулах санал боловсруулж, бодлогыг байнга сайжруулан шинэчлэнэ.
- 7.4 ББСБ-ын ажилтан болон эрх бүхий албан тушаалтан нь Эрсдэлийн удирдлагын бодлого болон холбогдох журам, заавар, Ажлын байрын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдэлийг удирдах болон ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчиж, байгууллага болон харилцагчид хохирол учруулсан нь нотлогдсон тохиолдолд дараах арга хэмжээг авна. Үүнд:
- 7.4.1 “Хөдөлмөрийн тухай хууль”, ББСБ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах;
 - 7.4.2 эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх;
 - 7.4.3 гэмт хэргийн шинжтэй нь баримтаар нотлогдсон тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;
 - 7.4.4 ББСБ-ын нэр хүндэд гэм хор учруулсан нь нотлогдсон тохиолдолд учирсан хохирлыг тухайн ажилтан, албан тушаалтан хариуцан барагдуулна.

“БҮРЭНФИНАНС ББСБ” ХХК